



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №23



2018 оны 7-р сарын 02-06-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 7 дугаар сарын 06-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **1028** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 75(7.3%) галзуугийн эрсдэлд өртсөн, 944(91.8%) хачигт халдвар, 2(0.2%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 6(0.6%)-ийг боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 944 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.1%-иар, эпидемиологийн 26-р долоо хоногтой харьцуулахад 22 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



7 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар хачигт риккетисозы 711 сэжигтэй тохиолдлын 138(19.4%), хачигт энцефалитын 148 сэжигтэй тохиолдлын 24(16.2%), хачигт боррелиозын 85 сэжигтэй тохиолдлын 22(26.8%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 113 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 75 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 31.8%-иар буурсан. Эпидемиологийн 26-р долоо хоногтой харьцуулахад 4 эрсдэлд өртсөн тохиолдлоор илүү байна.



1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 4 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит хүлээн аваад байна.

1.5 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн.

Хариу арга хэмжээ:

- Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан.
- Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2018 оны гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, *СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 28 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тайлбар (*2 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн)

7 дугаар сарын 02-06-ний хооронд СХД-ийн хэмжээнд 2 удаагийн ирүүлсэн амьтны дуудлагад үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилгээ хийхээр хүлээн авав.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол: Хэнтий ЗӨСТ

6-р сарын 28-наас, 7-р сарын 05-ны хооронд Хэнтий аймгийн Хэрлэн, Баянхутаг суманд галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 4 тохиолдол бүртгэгдэж, галзуугийн эсрэг вакцинд хамрагдсан байна.

Эх сурвалж: Хэнтий аймгийн ЗӨСТ

Мал, амьтны галзуу өвчин:

Архангай аймгийн Хотонт сумын Өндөр-Сант багийн “Давгасайхан булаг” гэдэг газар 7 дугаар сарын 04-ны өдөр малчин айлын хонинд шүлхий өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч УМЭАЦТЛ-ийн шинжилгээгээр шүлхий өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон. Тус суманд 7 дугаар сарын 04-нд хорио цээрийн дэглэм тогтоож, голомтот нутгийн 21 өрхийн хүн амд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийсэн.




Эх сурвалж: Архангай аймгийн ЗӨСТ

Олон улсад:

Хонины цэцэг өвчин: Грек улс

Грек улсын Лэсбос хотын Ворейо Айгайо мужийн хонины аж ахуйд “Каприпокс” төрлийн үүсгэгчээр үүсгэгдсэн хонины цэцэг өвчин бүртгэгдэж 299 хоныг устгасан байна. Голомтын бүсэд хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхийн вакцинжуулалт: Ботсвана улс

Ботсвана улсын Нгамиланд мужийн 1382 үхэрт шүлхий өвчний вакцинжуулалт хийгдсэн.

Эх сурвалж: ДАЭМБ


Мал, амьтны боом өвчин: Унгар улс

Унгар улсын Жасз-Нагукун-Шзолнок мужид мал, амьтны боом өвчний улмаас, 1 үхэр өвчилж, 1 үхрийг устгасан байна. Тус мужид тандалтын хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Рифт хөндийн чичрэг өвчин: Кени улс

Кени улсад рифт хөндийн чичрэг өвчний улмаас, 150 үхэр, 200 ямаа, 90 хонь өртөмхий байснаас, 6 үхэр, 21 ямаа, 11 хонь өвчилсөн байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн халуурал өвчин: Румын улс

Румын улсын Тулсеа хотын мужид африкийн гахайн халуурал өвчин бүртгэгдэж, 1 гахайг устгасан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Хантавирусын халдвар: Бүгд Найрамдах Панам улс

Бүгд Найрамдах Панам улсын Лос Сантос хотод Хантавируст халдварын 1 тохиолдлыг мэдээлсэн байна. Өвчтөн 9 настай, Лос Сантос хотын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна.

Эх сурвалж: Promed

Шүлхий өвчин: БНХАУ

БНХАУ-ын Юнань мужийн малын худалдааны захад “О” хэвшлээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 62 гахай өртөмхий байснаас, 1 гахай өвчилж үхэн, 61 гахайг устгасан байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу, Ньюкасл өвчин: Бельги улс

Бельги улсын Хаалтерт хотын Ост-Влаандэйрн мужид шувууны томуугийн ньюкасл халдварын дэгдэлт шувууны аж ахуйд бүртгэгдэж, 3648 шувууг устгасан байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Холерын халдвар: БНСУ

6 дугаар сарын 30-нд БНСУ-ын Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төвөөс холерын өвчлөлийн 2 тохиолдлыг мэдээлжээ. Энэтхэгийн Мумбай хотод зорчиж явахдаа халдвар авсан өгүүлэмжтэй. /2 тохиолдол лабораториор батлагдсан/. Тохиолдлуудыг тусгаарлан эмчилж байна. Идэвхтэй тандалт хийж, БНСУ-ын Агаарын тээвэрээс эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

Эх сурвалж: <http://www.cdc.go.kr>

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Багануур, Хэнтий, Завхан, Төв, Увс, Хөвсгөл аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?